ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

# Өвөрхангай аймаг дахь Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ӨВА-2024/15/НА-СТА-ТӨА**

Цахим хуудас: www.audit.mn
Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум
2024 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал
Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Гансүх
Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com
Аудитор: Р.Цэрэндолгор
Утас: 70323108 Цахим хаяг: Tserendolgorr@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Хараат бус аудиторын дүгнэлт ....................
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....................
3. Санхүүгийн тайлангийн тодруулга....................
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа....................
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ....................
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал....................
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт ....................
4. Аудитын тайлан ....................
   4.1 Ерөнхий зүйл ....................
   4.2 Материаллаг байдал ....................
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт....................
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....................
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....................
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....................
5. Аудитын илрүүлэлт ....................
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ЗГХЭГ | Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар |
| ХХОАТ | Хувь Хүний Орлогын Албан Татвар |
| ТЕЗ | Төсвийн Ерөнхийлөн захирагч |

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.23 № 109

танай ____________-ны №____________-т

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ НИСЭХ БУУДЛЫН ДАРГА А.МӨНХБАТ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Өвөрхангай аймгийн Нисэх буудлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Өвөрхангай аймгийн Нисэх буудлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно

**Аудитын гол асуудал**

ИНУТ-ийн харьяа Өвөрхангай аймаг дахь салбар нь Арвайхээр, Хужирт, Хархорин нисэх буудал болон Богд-Далан олон улсын өнгөрөлтийн станц гэсэн 4 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Тус байгууллага нь 2023 оны төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 939.3 сая төгрөгийн санхүүжилт авч, 5.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, нийт 940.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

015...070

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ө.БАТЖАРГАЛ

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1.1.1 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 1,597,867.24 | 3,020,306.15 |
| 1.1.2 | Дансны авлага | 0 | 2,493,722.00 |
| 1.1.6 | Бараа материал | 39,473,462.30 | 27,397,212.11 |
| | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **41,071,329.53** | **32,911,240.25** |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 2,286,093,336.92 | 1,752,620,738.27 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 48,828,073,942.36 | 48,827,666,884.01 |
| 1.2.7 | Хойшлогдсон татварын хөрөнгө | 753,049.97 | 4,538,954.93 |
| | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **51,114,920,329.26** | **50,584,826,577.21** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **51,155,991,658.79** | **50,617,737,817.47** |
| 2.1.1.3 | Татварын өр | 0 | 10,336.00 |
| | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **0** | **10,336.00** |
| **2.2** | **Өр төлбөрийн нийт дүн** | **0** | **10,336.00** |
| **2.3** | **Эздийн өмч** | **49,644,872,224.13** | **49,235,149,112.09** |
| 2.3.1 | Өмч: - төрийн | 48,825,426,000.00 | 48,825,426,000.00 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 819,446,224.13 | 409,723,112.09 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | 1,511,119,434.66 | 1,382,578,369.38 |
| | **Эздийн өмчийн дүн** | **51,155,991,658.79** | **50,617,727,481.47** |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **51,155,991,658.79** | **50,617,737,817.47** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Мөр | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | Борлуулалтын орлого (Цэвэр) | 1,382,799.57 | 3,955,319.64 |
| 2 | Борлуулалтын өртөг | 1,008,181,970.24 | 1,497,877,969.32 |
| **3** | **Нийт ашиг (алдагдал)** | **-1,006,799,170.67** | **-1,493,922,649.68** |
| 5 | Хүүгийн орлого | 0 | 136,707.02 |
| 8 | Бусад орлого | 1,920,204,832.02 | 1,034,510,171.97 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 0 | 1,800,000.00 |
| 12 | Бусад зардал | 37,622,317.03 | 77,188,406.64 |
| **18** | **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **875,783,344.32** | **-538,264,177.33** |
| **20** | **Татварын дараах ашиг ( алдагдал)** | **875,783,344.32** | **-538,264,177.33** |
| **22** | **Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)** | **875,783,344.32** | **-538,264,177.33** |

| | | | |
|---|---|---|---|
| 28 | **Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)** | **875,783,344.32** | **-538,264,177.33** |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

| Д/д | Үзүүлэлт | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **48,825,426,000.00** | **819,446,224.13** | **1,511,119,434.66** | **51,155,991,658.79** |
| **3** | **Залруулсан үлдэгдэл** | **48,825,426,000.00** | **819,446,224.13** | **1,511,119,434.66** | **51,155,991,658.79** |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал ) | 0 | 0 | 0 | 0 |
| **9** | **2022 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл** | **48,825,426,000.00** | **819,446,224.13** | **1,511,119,434.66** | **51,155,991,658.79** |
| 10 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | 0 | 0 | 0 | 0 |
| **11** | **Залруулсан үлдэгдэл** | **48,825,426,000.00** | **819,446,224.13** | **1,511,119,434.66** | **51,155,991,658.79** |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал ) | 0 | 0 | -538,264,177.33 | -538,264,177.33 |
| 14 | Өмчид гаргасан өөрчлөлт | 0 | -409,723,112.04 | 409,723,112.04 | 0 |
| **17** | **2023 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл** | **48,825,426,000.00** | **409,723,112.09** | **1,382,578,369.38** | **50,617,727,481.47** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Д/д | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | 0 | 0 |
| **1.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **875,539,606.00** | **944,770,022.21** |
| 1.1.3 | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 1,000,000.00 | 0 |
| 1.1.5 | Татаас, санхүүжилтийн орлого | 873,461,100.00 | 939,300,000.00 |
| 1.1.6 | ҮҮА-ны бусад мөнгөн орлого | 1,078,506.00 | 5,470,022.21 |
| **1.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **874,291,331.87** | **940,530,890.32** |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 451,924,824.05 | 485,201,887.22 |

| | | | |
|---|---|---|---|
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 138,923,322.78 | 144,610,871.69 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 55,970,936.00 | 50,223,490.00 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 33,723,851.29 | 35,666,296.43 |
| 1.2.5 | Хүүгийн төлбөрт төлсөн | 0 | 3,334.70 |
| 1.2.6 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 28,715,000.00 | 47,574,080.00 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 118,119,454.01 | 127,155,431.79 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | 0 | 16,280,414.27 |
| 1.2.9 | ҮҮА-ны бусад мөнгөн зарлага | 46,913,943.74 | 33,815,084.22 |
| **1.3** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **1,248,274.13** | **4,239,131.89** |
| **2.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **0** | **136,707.02** |
| 2.1.6 | Хүлээн авсан хүүгийн орлого | 0 | 136,707.02 |
| **2.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **0** | **2,953,400.00** |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 0 | 2,953,400.00 |
| **2.3** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **0** | **-2,816,692.98** |
| **4** | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **1,248,274.13** | **1,422,438.91** |
| **4** | **Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **1,248,274.13** | **1,422,438.91** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **349,593.11** | **1,597,867.24** |
| **6** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **1,597,867.24** | **3,020,306.15** |

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

| ҮЗҮҮЛЭЛТ | | 2022 оны гүйцэтгэл | 2023 оны Тодотгол | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| НИЙТ ЗАРЛАГА | | 890,314,896.27 | 1,041,643,700.00 | 938,678,396.28 | 102,965,303.72 | 90.1 |
| НИЙТ УРСГАЛ ЗАРДАЛ | | 890,314,896.27 | 1,041,643,700.00 | 938,678,396.28 | 102,965,303.72 | 90.1 |
| БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 883,814,896.27 | 1,030,243,700.00 | 933,678,396.28 | 96,565,303.72 | 90.6 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | | 548,573,288.77 | 638,280,000.00 | 575,843,484.86 | 62,436,515.14 | 90.2 |
| 1 | Үндсэн ба нэмэгдэл цалин | 454,568,288.77 | 547,728,900.00 | 492,490,706.86 | 55,238,193.14 | 89.9 |
| 2 | Унаа хоолны хөнгөлөлт | 94,005,000.00 | 90,551,100.00 | 83,352,778.00 | 7,198,322.00 | 92.1 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 74,538,597.34 | 84,121,200.00 | 78,089,870.82 | 6,031,329.18 | 92.8 |
| 1 | Тэтгэврийн даатгал | 46,893,929.73 | 54,253,800.00 | 49,167,696.33 | 5,086,103.67 | 90.6 |
| 2 | Тэтгэмжийн даатгал | 5,516,932.95 | 6,382,800.00 | 5,784,435.06 | 598,364.94 | 90.6 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3 | ҮОМШ-ийн даатгал | 9,990,479.35 | 9,442,400.00 | 10,411,982.84 | -969,582.84 | 110.3 |
| 4 | Ажилгүйдлийн даатгал | 1,103,389.56 | 1,276,600.00 | 1,156,886.92 | 119,713.08 | 90.6 |
| 5 | Эрүүл мэндийн даатгал | 11,033,865.75 | 12,765,600.00 | 11,568,869.67 | 1,196,730.33 | 90.6 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 30,963,051.91 | 54,561,900.00 | 36,828,650.45 | 17,733,249.55 | 67.5 |
| 1 | Гэрэл, цахилгаан | 19,716,226.16 | 34,235,900.00 | 22,752,016.77 | 11,483,883.23 | 66.5 |
| 2 | Түлш, халаалт | 10,545,334.83 | 19,141,700.00 | 13,507,383.68 | 5,634,316.32 | 70.6 |
| 3 | Цэвэр, бохир ус | 701,490.92 | 1,184,300.00 | 569,250.00 | 615,050.00 | 48.1 |
| Хангамж, бараа материалын зардал | | 32,788,335.11 | 48,414,800.00 | 45,464,668.58 | 2,950,131.42 | 93.9 |
| 1 | Бичиг хэрэг | 1,332,183.97 | 1,680,300.00 | 1,262,505.35 | 417,794.65 | 75.1 |
| 2 | Тээвэр, шатахуун | 26,252,182.99 | 38,080,100.00 | 37,165,669.96 | 914,430.04 | 97.6 |
| 3 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,345,345.12 | 5,949,100.00 | 5,265,513.81 | 683,586.19 | 88.5 |
| 4 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 837,899.69 | 1,707,500.00 | 1,480,067.90 | 227,432.10 | 86.7 |
| 5 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,020,723.34 | 997,800.00 | 290,911.56 | 706,888.44 | 29.2 |
| Нормативт зардал | | 2,227,681.84 | 0.00 | 0.00 | 0 | 0.0 |
| 1 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,227,681.84 | 0.00 | 0.00 | 0 | 0.0 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | | 83,336,960.88 | 68,136,900.00 | 80,394,294.91 | -12,257,394.91 | 118.0 |
| 1 | Багаж, техник, хэрэгсэл | 64,283,178.39 | 36,143,900.00 | 49,582,915.23 | -13,439,015.23 | 137.2 |
| 1 | Тоног төхөөрөмж | 37,452,786.55 | 12,511,500.00 | 29,085,747.64 | -16,574,247.64 | 232.5 |
| 2 | Автомашин | 2,897,111.97 | 3,442,600.00 | 2,623,984.46 | 818,615.54 | 76.2 |
| 3 | Аэродром | 21,546,870.71 | 16,840,200.00 | 17,175,256.90 | -335,056.90 | 102.0 |
| 4 | Гал унтраах зардал | 2,386,409.16 | 3,349,600.00 | 697,926.23 | 2,651,673.77 | 20.8 |
| 5 | Хөдөлмөр хамгааллын зардал | 3,033,084.37 | 11,658,100.00 | 11,474,710.91 | 183,389.09 | 98.4 |
| 6 | Урсгал засвар | 16,020,698.12 | 20,334,900.00 | 19,336,668.77 | 998,231.23 | 95.1 |
| Томилолт, зочны зардал | | 5,492,667.49 | 13,655,900.00 | 15,434,957.26 | -1,779,057.26 | 113.0 |
| 1 | Дотоод албан томилолт | 5,492,667.49 | 13,655,900.00 | 15,434,957.26 | -1,779,057.26 | 113.0 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 94,903,387.10 | 113,410,300.00 | 100,858,799.40 | 12,551,500.60 | 88.9 |
| 1 | Харуул, хамгаалалтын зардал | 454,545.32 | 2,125,000.00 | 1,062,101.95 | 1,062,898.05 | 50.0 |
| 2 | Үл хөдлөх хөрөнгийн татвар | 2,308,005.74 | 2,326,100.00 | 2,475,877.18 | -149,777.18 | 106.4 |
| 3 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 193,050.00 | 1,807,300.00 | 1,800,000.00 | 7,300.00 | 99.6 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | Даатгалын үйлчилгээ | 14,375,600.00 | 16,333,300.00 | 16,280,414.27 | 52,885.73 | 99.7 |
| 5 | Тээврийн хэрэгслийн татвар | 350,500.00 | 381,700.00 | 350,500.00 | 31,200.00 | 91.8 |
| 6 | Газрын төлбөр | 77,133,486.00 | 90,256,900.00 | 78,803,906.00 | 11,452,994.00 | 87.3 |
| 7 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 88,200.04 | 180,000.00 | 86,000.00 | 94,000.00 | 47.8 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | | 8,763,243.99 | 9,662,700.00 | 763,670.00 | 8,899,030.00 | 7.9 |
| 1 | Бараа үйлчилгээний бусад зардал | 451,954.89 | 8,412,700.00 | 13,670.00 | 8,399,030.00 | 0.2 |
| 2 | Сургалт семинар | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.0 |
| 3 | Дотоод сургалт | 8,311,289.10 | 1,250,000.00 | 750000 | 500,000.00 | 60.0 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 6,500,000.00 | 11,400,000.00 | 5,000,000.00 | 6,400,000.00 | 43.9 |
| 1 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.0 |
| 2 | Ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж | 4,700,000.00 | 9900000 | 3500000 | 6400000 | 35.4 |
| 3 | Эмчилгээний төлбөр | 1,800,000.00 | 1500000 | 1,500,000.00 | 0.00 | 100.0 |
| НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН ДҮН | | | | | | |
| НИЙТ ОРЛОГЫН ДҮН | | 1,382,800.00 | 4,500,000.00 | 4,092,030.00 | 407,970.00 | 90.9 |
| 1 | Буулт, хөөрөлтийн орлого | 1,340,600.00 | 1,500,000.00 | 588,290.00 | 911,710.00 | 39.2 |
| 2 | Зорчигч үйлчилгээний орлого | | 0.00 | | 0.00 | 0.0 |
| 3 | Бусад орлого | 42,200.00 | 3,000,000.00 | 3,503,740.00 | -503,740.00 | 116.8 |
| НИЙТ САНХҮҮЖИЛТИЙН ДҮН | | | | | | |
| 4 | Иргэний нисэхийн үндэсний төвийн санхүүжилт | 873,461,100.00 | 0.00 | 939,300,000.00 | -939,300,000.00 | |

## 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

### 3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа

Өвөрхангай аймаг дахь Нисэх буудал нь Иргэний нисэхийн талаар зайлшгүй хэрэгжүүлэх чиг үүрэг, үйлчилгээг хэрэгжүүлэх Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ИНЕГ-ын харьяа байгууллага юм. Тус байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна.

- Нисэхийн болон нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт, захицуулалт хийх
- Нислэгийн хөдөлгөөний удирдлага үйлчилгээ, холбоо нагивацийн техник тоног төхөөрөмжийн үйлчилгээ, нисэхийн мэдээлэл хангалтийн үйлчилгээ үзүүлэх
- Иргэний хисэхийн үйлчилгээ
- Нисэх буудал, газрын тусгай үйлчилгээ
- Эдийн засгийн зохицуулалт

ИНЕГ-ын харьяа Өвөрхангай аймаг дахь салбар нь Арвайхээр, Хархорин, Хужирт хисэх буудал болон Богд-Далан олон улсын өнгөрөлтийн станц гэсэн 4 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулдаг. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Иргэний нисэхийн үндэсний төв Төрийн өмчит ААТҮГ, Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Өвөрхангай нисэх буудал гэсэн статустай өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

### 3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин

ИНЕГ-ын харьяа Өвөрхангай аймаг дахь Арвайхээр нисэх буудал нь Иргэний нисэхийн тухай хууль, Иргэний нисэхийн багц дүрэм холбогдох хууль, тогтоомжууд, Аэродромын үйл ажиллагааны заавар, Иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангахтай холбогдон гарсан хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Өвөрхангай аймаг дахь Нисэх буудлын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өвөрхангай аймаг дахь Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус ТӨҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өвөрхангай аймаг дахь Нисэх буудал ТӨҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуй нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 538,253.8 мянган төгрөгөөр *буурсан* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 1,597.9 | 3,020.3 | 1,422.4 |
| Авлага | 0 | 2,493.7 | 2,493.7 |
| Бараа материал | 39,473.5 | 27,397.2 | -12,076.3 |
| Үндсэн хөрөнгө | 51,114,920.3 | 50,584,826.6 | -530,093.7 |
| **Нийт хөрөнгө** | **51,155,991.6** | **50,617,737.8** | **-538,253.8** |

| | | | |
|---|---|---|---|
| Өр төлбөр | 0 | 10.3 | 10.3 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 51,155,991.6 | 50,617,727.5 | -538,264.1 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **51,155,991.6** | **50,617,737.8** | **-538,253.8** |

Дээрх хүснэгтээс харахад, тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх мөнгөн хөрөнгө өмнөх оноос 1,422.4 мянган төгрөгөөр буюу 189 хувиар өссөн байна.

Авлага дансны үлдэгдэл 2,493.7 мянган төгрөгөөр өссөн нь нислэгийн мэдээллийн ажилтан мэдээгээ дутуу гаргаж өгсөн, харилцагч 5 байгууллагатай тайлант ондоо багтаж тооцоо нийлээгүйтэй холбоотой үүссэн байна.

Бараа материал дансны үлдэгдэл 12,076.3 мянган төгрөгөөр буурсан нь ИНҮТ-өөс сэлбэг материалыг авчирч засвар үйлчилгээ хийдэг бөгөөд хоорондын тооцоогоор орж ирээд гардагтай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө 530,093.7 мянган төгрөгөөр буурсан нь ИНҮТ-өөс үндсэн хөрөнгүүдийг шаардлагатай газар нь шилжүүлж зохицуулалт хийдэгтэй холбоотой ба Далангийн ОУӨС-аас холбоо нагиваци ажиглалтын албанд 04-04-00048 кодтой хөрөнгө шилжсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр 10.3 мянган төгрөгөөр өссөн нь хүүгийн татварт өглөг бүртгэгдээгүй байсныг нөхөж бүртгэсэн байна.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Өвөрхангай аймаг дахь Нисэх буудал үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ИНЕГ-ын 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн шийдвэрээр Өвөрхангай аймаг дахь Нисэх буудлын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант онд нийт орлогыг 1,040,164.4 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,040,164.4 мянган төгрөгөөр тогтоосон ба 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн шийдвэрээр нийт орлогыг 1,041,643.8 мянган төгрөг буюу 1,479.4 мянган төгрөгөөр нэмж тодотгол хийсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 939,300.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 5,470.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, байгууллага хоорондын тооцоогоор 147,135.0 мянган төгрөгийн орлого шилжүүлэн авч 1,576,866.4 мянган төгрөгийг зарцуулж 538,264.1 мянган төгрөгийн татварын өмнөх алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 4,500.0 мянган төгрөг төлөвлөснөөс 4,092.0 мянган төгрөг буюу 9 хувиар тасарсан нь тогтмол нислэггүй, дотоодын нисэхийн агаарын хөлөгт үйлчлэх үйлчилгээний үнэ тариф шинэчлэгдээгүй, ИНЕГ-ын даргын 2004 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 311 тоот тушаалаар баталсан тариф үнэлгээг мөрддөг зэргээс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 1,576,866.4 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 538,264.2 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь системийн хоорондын тооцоогоор орсон орлого гол нөлөө үзүүлсэн байна.

## 4.Аудитын тайлан

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж

заасны дагуу Өвөрхангай аймаг дахь Нисэх буудлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани /ТӨҮГ/, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Цэрэндолгор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Өвөрхангай аймаг дахь Нисэх буудал 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугээр сарын 21-ны өдрийн 09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн орлого үр дүнгийн тайлагналын нийх зардал 1,576,866.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 15,768.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тайлант онд дараах зардлуудыг батлагдсан төсвөөс хэмнэлттэй зарцуулжээ. Үүнд:

- ✓ Бичиг хэрэг зардалд 1,680.3 мянган төгрөг батлагдсанаас 1,262.5 мянган төгрөг зарцуулж 417.8 мянган төгрөгийг хэмнэсэн
- ✓ Тээвэр шатахуун зардалд 38,080.1 мянган төгрөг батлагдсанаас 37,165.7 мянган төгрөг зарцуулж 914.4 мянган төгрөгийг хэмнэсэн
- ✓ Шуудан, холбоо, интернэтийн зардалд 5,949.1 мянган төгрөг батлагдсанаас 5,265.5 мянган төгрөг зарцуулж 683.6 мянган төгрөгийг хэмнэсэн.
- ✓ Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн зардалд 1,707.5 мянган төгрөг батлагдсанаас 1,480.0 мянган төгрөг зарцуулж 227.4 мянган төгрөгийг тус тус хэмнэсэн байна.
- ✓ Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс зардалд 997.8 мянган төгрөг батлагдсанаас 290.9 мянган төгрөг зарцуулж 706.9 мянган төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өвөрхангай аймаг дахь Нисэх буудал нь Шилэн дансны тухай хууль, журмын дагуу батлагдсан маягтаар мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд бүрэн байршуулсан байна.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шилэн дансны нэг зөвлөмж хүргүүлсэн, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | **0** | **0** | **0** | **0** | **0** |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | 1 | 0 | | 1 | 100% |
| **Нийт дүн** | **1** | **0** | **0** | **1** | **100%** |

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

### 5.1 Төлбөрийн акт

Тус байгууллага дээр акт гараагүй.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага тавиагүй.

### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулга гараагүй.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6217143681
ЙЮА0059 9044094